

БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/383

Улаанбаатар хот

“Оюутан, сонсогчдын ёс зүйн дүрэм”, суралцуулах гэрээг батлах тухай

Монгол Улсын БСШУ-ны сайдын 2010 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын хоёр дахь хэсгийн 2.1.7, 2.1.8 дахь заалтууд, БХИС-ийн захиргааны зөвлөлийн 2012 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “БХИС-ийн оюутан, сонсогчдын ёс зүйн дүрэм”-ийг нэгдүгээр, БХИС-ийн суралцагчтай байгуулах гэрээний загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “БХИС-ийн оюутан, сонсогчдын ёс зүйн дүрэм”-ийг нийт бүрэлдэхүүнд сурталчлан таниулах арга хэмжээг өндөр хэмжээнд төлөвлөн зохион байгуулж, 2012 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг бүрэлдэхүүн сургуулиудын захирал, нийгмийн ажилтнууд, соёл, хүмүүжлийн тасаг, сонсогч, оюутны холбооны удирдлагад, суралцагч нэг бүртэй шинэчлэгдсэн гэрээг байгуулж, албажуулахыг СБЗА-ны дарга хурандаа Ч.Цогтжаргалд тус тус даалгасугай.

3. “Оюутан, сонсогчдын ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилт, суралцагсадтай байгуулсан гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг БХИС-ийн Сургалт хариуцсан дэд захирал хурандаа Ж.Энхбаяр, Захиргаа удирдлагын албаны дарга хурандаа М.Буянжаргал нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

БРИГАДЫН ГЕНЕРАЛ

З.БОЛДБААТАР.

БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ОЮУТАН, СОНСОГЧДЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Энэхүү дүрмээр БХИС-ийн /цаашид сургууль гэх/ бакалаврын зэрэг олгох түвшинд суралцаж буй оюутан, сонсогчдын /цаашид суралцагч гэх/ дагаж мөрдвөл зохих зан төлөв, ёс суртахууны нийтлэг хэм хэмжээг тогтоож, суралцагчдын үйл ажиллагаанд хэвшүүлэх, зөрчил дутагдал гаргагчдад хамт олны эерэг нөлөөг үзүүлж, хүмүүжлийн ажил, арга хэмжээг зохион байгуулснаар нийгэм, Зэвсэгт хүчинд мэргэжлийн болон ёс зүйн өндөр төлөвшил, хүмүүжилтэй иргэнийг бэлтгэх, суралцагчдын хариуцлагын тогтолцоог бүрдүүлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. “БХИС-ийн оюутан, сонсогчдын ёс зүйн дүрэм” нь “Монголын оюутны ёс зүйн дүрэм”-ийн бүрэлдэхүүн хэсэг байж, тус сургуулийн бакалаврын зэргийн суралцагсдад жигд хамаарна.

1.3. БХИС-ийн суралцагч нь “**Эх орон, эрдэм мэдлэг, эр зориг, тэсвэр хатуужил**” уриан дор Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын заалт болон суралцагчийн гэрээгээр хүлээсэн үүргээ чанд сахин биелүүлж, сурах үйлсэд өөрийн идэвх зүтгэл, бүхий л боломжоо дайчлан, сургууль, хамт олноос зохион байгуулж буй арга хэмжээнд идэвхи, санаачлагатай оролцдог, бусдын эрх ашгийг хүндэтгэндээдэлдэг байна.

1.4. Суралцагч гэмт хэрэг үйлдсэн бол хуулийн дагуу хариуцлагаа хүлээх ба гэмт хэргийн шинж чанаргүй зөрчил дутагдал гаргасан бол түүний сэдэл, нөхцөл байдал, нийгэм, сургууль, хамт олонд үзүүлэх нөлөө, хор холбогдол зэргээс шалтгаалан энэ дүрмийн дагуу хариуцлага хүлээнэ.

1.5. Сахилгын зөрчил дутагдал гаргасан нийт суралцагсад БХИС-ийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээхээс гадна, сонсогчид цэргийн сахилгын дүрмийн дагуу шийтгэгдэнэ.

Хоёр. Ёс зүйн зөрчлийн тухай ойлголт, хэлбэр

2.1. Ёс зүйн зөрчил гэдэгт ёс зүйн үндсэн зарчмууд, нийгмийн зан суртахууны түгээмэл хэм хэмжээнд харшилсан, шууд болон шууд бус байдлаар хохирол учруулсан, энэхүү дүрэмд заасан бүрэлдэхүүн, хэлбэр болох ёс зүйн сөрөг үнэлэмж бүхий үйлдэл болон эс үйлдэхүйг ойлгоно.

2.2. Ёс зүйн зөрчлийг Монгол Улсын хууль, Батлан хамгаалах салбар, дээд боловсролын байгууллага, БХИС-ийн хэмжээнд дагаж мөрдөх хууль, тогтоомж, цэргийн дүрэм, журмуудын хүрээнд авч үзэх ба нийгэм, хамт олонд учруулсан аюул, хор уршгийн хэмжээг харгалзан **хөнгөн, хүндэвтэр, хүнд** гэж гурав ангилна.

2.3. Ёс зүйн зөрчлүүдэд дараах сөрөг үйлдлүүдийг хамааруулна.

2.3.1. БХИС, хамт олны нэр хүндийг ноцтойгоор унагаах үйлдэл гаргах, гаргахыг завдах, сургуулийн удирдлага, захиргааны шийдвэр, багш ажиллагсад, дарга, захирагч нарынхаа зүй ёсны шаардлагыг үл хүндэтгэн биелүүлэхээс зайлсхийх;

2.3.2. Цэргийн сургуулийн суралцагсадын онцлог болох ёсолж хүндэтгэх ажиллагаа, жагсаалч байдлыг үл хэрэгжүүлэх;

2.3.3. Цэргийн болон оюутны дүрэмт хувцасыг хэрэглэх ба хувцас өмсөх зааврыг зөрчих, өнгө үзэмж алдсан хувцас өмсөж, ард иргэдийн дунд сургууль, өөрийн болон хамт олныхоо нэр хүндийг гутаах, сонсогч, оюутан бүрийн биедээ авч явах хувийн бичиг баримтаа шалгуулахаас зайлсхийх, сургуулийн орчинд бичиг баримтгүйгээр нэвтрэх;

2.3.4. Сургуулийн орчинд болон олон нийтийн газар цэргийн болон оюутны дүрэмт хувцастайгаар архи, согтууруулах ундааны зүйлс, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх

бодис хэрэглэх, тусгайлан зөвшөөрснөөс бусад орчинд тамхи татах, олон нийтийн дунд бүдүүлэг үг хэллэг хэрэглэх зэргээр хувийн соёлгүй үйлдэл гаргах, биеэ зүй бус авч явах;

2.3.5. Хичээл сургууль, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, ангийн болон график тооцооны ажил, дипломын ажил зэргийг бичих явцад бусдын оюуны бүтээл, нээлтийн ололтыг зөвшөөрөлгүй ашиглах, хууль бусаар өөрийн болгох зэрэг зохисгүй үйлдэл гаргахгүй, оюун санааны цэвэр ариун байх тогтсон дэгийг зөрчихгүй байх;

2.3.6. Бусдын эрх чөлөөнд бүдүүлгээр халдах, айлган сүрдүүлэх, дарамтлах, хамт суралцагсадынхаа сурч боловсрох эрхэд санаатайгаар саад учруулах;

2.3.7. Хичээл таслах, хожимдох, сурлагын дүнгээ өөрчилж, журнал болон сурлагын дэвтрийг засах, багшийн гарын үсгийг хуурамчаар дуурайн үйлдэх, сургалтын явцын болон төгсөлтийн шалгалт, улсын шалгалтын журмыг зөрчих, шалгалтын материалыг санаатайгаар задлах, тараах;

2.3.8. Хичээлийн болон цэргийн байрны эд хогшлыг ариг гамгүй хэрэглэх, санаатай эвдэх, өнгө үзэмж чанарыг алдагдуулах;

2.3.9. Ёс суртахууны ноцтой зөрчил гарсан болон хэн гаргасныг мэдэж байсан боловч зүй бус явдалтай эвлэрсэн, санаатайгаар нуун далдалсан үйлдэл хийх;

2.3.10. Нийгмийн зан суртахууны бусад түгээмэл хэм хэмжээ, цэргийн дүрэм, БХИС-ийн дүрэм, дотоод журамд харшилсан аливаа үйлдэл, эс үйлдэл гаргахыг хамааруулна.

Гурав. БХИС-ийн суралцагчдын ёс зүйн үндсэн болон тусгай зарчим

3.1. БХИС-ийн эрхэм зорилго, зорилт, суралцагчдын уриаг дээдлэн, сургуулийнхаа нэр хүндийг өндөрт өргөн, сурах үйлсэд өөрийн хүч оюуныг бүрэн дайчлан, сонгосон мэргэжилдээ шамдан суралцаж, эх орон, Зэвсэгт хүчнийхээ хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах шилдэг, чадварлаг боловсон хүчин болох;

3.1. Сургуулийн бүх талын үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон хууль, тогтоомж, цэргийн дүрэм, журам, энэхүү дүрмээр тогтоосон ёс зүйн шаардлагуудыг ёсчлон биелүүлэх;

3.2. Сургуулийн удирдлага, эрдэмтэн багш, ажиллагсад, захирагч дарга нараа хүндэтгэн харьцах;

3.3. Хамтран суралцаж буй суралцагсаддаа аливаа байдлаар саад хийхгүй, оюуны эрэл хайгуулд хамтдаа зүтгэгч нөхөр хэмээн тусалж дэмжин, хүнлэг энэрэнгүй, нөхөрсөг, нийтэч харьцах;

3.4. Сургалтын материаллаг бааз, хичээлийн танхим, сургалтын хэрэглэгдэхүүн, цэргийн байрны эд хөрөнгийг ариг гамтай ашиглах;

3.5. БХИС-ийн оюутан, сонсогчид иргэний нийтлэг эрх, эрх чөлөөг эдэлж, үүргээ биелүүлэн, сонсогч, оюутны холбооноос зохион байгуулж буй үйл ажиллагааг дэмжин, урлаг, спорт, соёл олон нийтийн ажил, арга хэмжээнд идэвхи санаачлагатай оролцохын зэрэгцээ, сонсогчид нь цэргийн жинхэнэ алба хаагчийн хувьд албаны онцлого, түүнд тавигдах шаардлага, өргөсөн тангарагтайгаа холбогдуулан эрх зүйн байдлын зарим хязгаарлалтад хамаарна. Үүнд:

/Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 29 дүгээр зүйлд заасан Улстөрийн зорилгоор эвлэлдэн нэгдэх, улстөрийн үйл ажиллагаа явуулах эвсэл, холбооны гишүүнчлэлд орох, захирагч даргын зөвшөөрөлгүйгээр цэргийн дүрэмд зааснаас бусад жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох, бусдыг татан оруулах зэрэг болно/.

3.6. Цэргийн болон сургууль, хамт олон, хувь хүний албан болон хувийн нууцыг хадгалах;

3.7. БХИС-ийн нийт суралцагчид нь дээрх үндсэн зарчмуудаас гадна нийгмийн ёс зүйн түгээмэл хэм хэмжээ, өөрийн суралцаж буй мэргэжлийн зан үйлийн тусгай зарчмуудыг сахин баримтлах үүрэгтэй.

Дөрөв. Ёс зүйн зөрчил гаргасныг тогтоох, зөрчил гаргагсдад хүлээлгэх хариуцлага

4.1. Сонсогч, оюутаны холбооноос суралцагч тус бүрт ёс зүйн карт олгон, зөрчил гаргах бүрт картыг цоолж, тэмдэглэл хөтлөх ба, гаргасан зөрчлийн тоо, хэм хэмжээ, хор холбогдол, нөхцөл байдлыг харгалзан доорхи хариуцлагуудыг “БХИС-ийн оюутны ёс зүйн зөвлөл”-өөс хүлээлгэнэ. /Хариуцлагыг заавал дэс дараалан оногдуулах албагүй ба гаргасан зөрчилд нь тохируулан хүлээлгэнэ/.

4.1.1. Сануулга өгөх;

4.1.2. Тодорхой болзолтойгоор сургуульд нь үргэлжлүүлэн сургах, эсвэл жилийн чөлөө олгох;

4.1.3. Сургуулиас хасах санал оруулах;

4.2. Сануулга өгөх арга хэмжээг ёс зүйн хөнгөн хэлбэрийн зөрчил гаргасан этгээдэд нэг жилийн хугацаанд 1-3 удаа оногдуулж болно.

4.3. Тодорхой болзолтойгоор үргэлжлүүлэн сургах, эсвэл жилийн чөлөө олгох арга хэмжээг ёс зүйн хүндэтэр зөрчил, мөн урьд нь 3 удаа сануулах арга хэмжээ авагдсан суралцагсдад хүлээлгэнэ.

4.4. Сургуулиас хасуулах арга хэмжээг ёс зүйн ноцтой зөрчил гаргасан этгээдийг тус сургуульд суралцахад ёс суртахууны хувьд тэнцэхгүй хэмээн үзэж БХИС-ийн захирал, захиргааны зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлнэ. /Эцэг эх буюу харгалзан дэмжигчид нь урьдчилан мэдэгдсэн байна/

4.5. Сургуулиас хасагдах шийтгэл хүлээсэн этгээдэд түүний сургалтын төлбөрийг буцаан олгохгүй ба дахин элсэн суралцах эрхгүй болно.

4.6. Зөрчил гаргагчийн нийгэм, хамт олонд учруулсан аюул, хор уршигийн хэмжээ нь энэхүү дүрмийн ёс зүйн хөнгөн, хүндэтэр, хүнд хэлбэрийн алинд хамаарахыг ёс зүйн зөвлөл хэлэлцэн тогтоож, хүлээлгэх хариуцлагын алинд багтаахыг шийдвэрлэнэ.

4.7. Энэхүү дүрэмд заасан ёс зүйн зөрчлийг мэдээгүй байсан нь хариуцлага хүлээхгүй байх үндэслэл болохгүй.

Тав. Ёс зүйн зөвлөл

1. БХИС нь ёс зүйн зөвлөлтэй байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд БХИС, бүрэлдэхүүн сургууль, тэнхимийн зарим удирдлага, багш, суралцагч, сонсогч, оюутны холбооны гишүүд, оюутны зөвлөл, эцэг эхийн төлөөллөөс гадна ахмадын болон хөндлөнгийн төлөөлөл орж болно.

Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хамт олны хурлаас 9-11 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2 жилийн хугацаатайгаар байгуулна.

Зөвлөлийн хурлыг шаардлагатай тохиолдолд ил тод, нээлттэй, шударга зарчмаар зохион байгуулж, хурлаар ёс зүйн дүрмийг зөрчсөн суралцагчдыг хэлэлцэн, алдаа, дутагдлыг нь ухамсарлуулж, хүмүүжүүлэн төлөвшүүлэх, дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, бусдад санамж болгох арга хэлбэрийг удирдлага болгон, шаардлагатай гэж үзвэл ёс зүйн хариуцлага хүлээлгэнэ.

Уг дүрмийн дагуу тооцогдсон ёс зүйн арга хэмжээг зөрчил гаргагч хүлээн зөвшөөрөх үндэслэлгүй гэж үзвэл сургуулийн сонсогч, оюутны холбоонд бичгээр хандан, сургуулийн сахилга, дэг журам, ажлын хариуцлагыг дээшлүүлэх салбар зөвлөл болон удирдлагад уламжлуулах эрхтэй.

Зургаа. Бусад зүйл

Энэхүү дүрмийг БХИС-ийн сонсогч, оюутны холбооноос боловсруулж, сургуулийн захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, захирлын тушаалаар баталгаажуулна.

СУРГАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБА.